

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:  
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:  
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:  
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Ц.Чагнаадорж

Утас: 99387994 Цахим хаяг:  
Chagnaadorj.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/319  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.ОДСЭР  
ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгө 511.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 24.0 сая төгрөгөөр тасалж, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон 9 зээлдэгчтэй холбоотой 18.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Баянзүрх сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт 133 арга хэмжээтэй хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 88.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		625,795.96	746,557.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	462,505.68	356,215.38
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	101,219.96	155,395.18
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	62,070.33	234,947.06
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,586,855.98	3,620,002.26
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	84,171	45,000
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,502,684.98	3,575,002.26
39200	Биет хөрөнгө		3,475,861.51	3,164,667.19
39300	Биет бус хөрөнгө	13	26,823.47	410,335.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		4,212,651.94	4,366,559.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		891.09	31,253.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		891.09	31,253.5
41300	Өглөг		891.09	31,253.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,211,760.85	4,335,306.38
51	Засгийн газрын хувь оролцоо		4,211,760.85	4,335,306.38
51100	Засгийн газрын оруулсан капитал		327,386.92	327,386.92
51200	Хуримтлагдсан үр дүн		3,361,795.94	3,486,248.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		522,577.99	521,671.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		4,212,651.94	4,366,559.88

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,009,378.96	2,454,675.11
11	ТАТВАРЫН ОРЛОГО		939,347.78	875,265.18
110	Орлогын албан татвар		646,884.16	627,787.88
110	Хувь хүний орлогын албан татвар		646,884.16	627,787.88
113	Хөрөнгийн албан татвар		100,585.57	80,032.68
118	Бусад татвар, төлбөр, хураамж		191,878.06	167,444.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	45,230.85	1,579,409.93
121	Хөрөнгийн орлого		0.0	5,990
122	Тусламжийн орлого		0.0	697,623.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,024,800.33	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,979,862.95	2,118,502.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,979,862.95	1,963,431.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,654,575.34	1,882,666.11

**Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		785,354.39	1,025,633.12
2102	нийгмийн даатгалд төлөх шимтгэл		98,953.96	128,843.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		220,570.52	240,945.18
2104	Хангамж, бараа материалын зардал		62,690.63	56,355.94
2105	Нормативт зардал		0.0	4,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		34,334.9	42,502.3
2107	Томилолт, зочны зардал		9,684	5,584.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		44,063.61	13,588.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		398,923.33	365,213.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		325,287.6	80,765.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	155,071.26
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		29,516.01	336,172.28
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.0	212,626.75
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		0.0	-212,626.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		29,516.01	123,545.53

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,048,680.27	1,844,644.45
11	ТАТВАРЫН ОРЛОГО	939,347.78	875,265.18
110	Орлогын албан татвар	646,884.16	627,787.88
113	Хөрөнгийн албан татвар	100,585.57	80,032.68
118	Бусад татвар, төлбөр, хураамж	191,878.06	167,444.62
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,808.82	20,593.55
1181	Газрын төлбөр	20,253.9	10,495.15
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	151,815.34	136,355.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,532.15	969,379.27
120	Нийтлэг татварын бус орлого	84,532.15	91,277.19
121	Хөрөнгийн орлого	0.0	5,990
122	Тусламжийн орлого	0.0	697,623.19
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	174,488.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,024,800.33	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,367,964.64	1,603,901.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,367,964.64	1,603,901.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,303,043.94	1,523,135.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	785,141.4	1,026,524.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,103.5	129,343.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	219,578.52	232,487.5

**Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	60,606.73	42,591.22
2105	Нормативт зардал	0.0	4,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,045.9	39,472.3
2107	Томилолт, зочны зардал	9,984	5,584.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,965.29	16,948.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,618.6	26,183.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,920.7	80,765.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	680,715.63	240,743.26
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	386,468.87	277,033.56
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	386,468.87	277,033.56
220	Дотоод эх үүсвэрээр	386,468.87	277,033.56
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-386,468.87	-277,033.56
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,000	70,000
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-75,000	-70,000
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	219,246.76	-106,290.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	243,258.92	462,505.68
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	462,505.68	356,215.38

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,182,244.84		4,182,244.84
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,182,244.84		4,182,244.84
9	Тайлант үеийн үр дүн	29,516.01		29,516.01
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,211,760.85		4,211,760.85
11	2025 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	4,211,760.85		4,211,760.85
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	906.8		906.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,212,667.65		4,212,667.65
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-906.8		-906.8
19	Тайлант үеийн үр дүн	123,545.53		123,545.53
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,335,306.38		4,335,306.38

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,209,819.10</b>	<b>1,878,253.92</b>	<b>331,565.18</b>	<b>85.00</b>
00185	<b>Татварын бус орлого</b>	<b>78,379.70</b>	<b>60,089.00</b>	<b>18,290.70</b>	<b>76.66</b>
00190	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	74,069.00	55,459.00	<b>18,610.00</b>	<b>74.87</b>

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

00191	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	4,310.70	4,630.00	-319.30	107.41
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,951,333.70</b>	<b>1,643,676.02</b>	<b>307,657.68</b>	<b>84.23</b>
122005	Төсвөөс санхүүжих	1,951,333.70	1,643,676.02	307,657.68	84.23
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>180,105.70</b>	<b>174,488.90</b>	<b>5,616.80</b>	<b>96.88</b>
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	180,105.70	174,488.90	5,616.80	96.88
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,209,819.00</b>	<b>1,943,364.96</b>	<b>266,454.04</b>	<b>87.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,660,039.40</b>	<b>1,607,851.71</b>	<b>52,187.69</b>	<b>96.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,577,522.30</b>	<b>1,527,086.25</b>	<b>50,436.05</b>	<b>96.80</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,039,431.00</b>	<b>1,025,253.10</b>	<b>14,177.90</b>	<b>98.64</b>
210101	Үндсэн цалин	517,650.60	504,253.04	13,397.56	97.41
210102	Нэмэгдэл	439,867.90	431,341.11	8,526.79	98.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,800.00	39,083.89	-16,283.89	171.42
210104	Урамшуулал	59,112.50	50,575.06	8,537.44	85.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>129,886.30</b>	<b>129,343.59</b>	<b>542.71</b>	<b>99.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	88,322.60	87,604.41	718.19	99.19
210202	Тэтгэмжийн даатгал	10,390.90	10,362.80	28.10	99.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,195.50	5,469.47	-273.97	105.27
210204	Ажилгүйдлийн даатгал	5,195.50	5,181.40	14.10	99.73
210205	Эрүүл мэндийн даатгал	20,781.80	20,725.50	56.30	99.73
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>238,356.90</b>	<b>232,487.50</b>	<b>5,869.40</b>	<b>97.54</b>
210301	Гэрэл, цахилгаан	91,747.50	87,342.03	4,405.47	95.20
210302	Түлш, халаалт	136,726.30	134,044.00	2,682.30	98.04
210303	Цэвэр, бохир ус	9,883.10	11,101.47	-1,218.37	112.33
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>55,086.90</b>	<b>40,292.54</b>	<b>14,794.36</b>	<b>73.14</b>
210401	Бичиг хэрэг	7,505.00	6,686.14	818.86	89.09
210402	Тээвэр, шатахуун	40,372.00	26,715.50	13,656.50	66.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,828.00	3,509.00	319.00	91.67
210404	Ном, хэвлэл	400.00	400.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,981.90	2,981.90	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>52,152.80</b>	<b>46,872.30</b>	<b>5,280.50</b>	<b>89.87</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000.00	5,000.00	3,000.00	62.50
210602	Тавилга	3,500.00	2,400.00	1,100.00	68.57
210604	Урсгал засвар	40,652.80	39,472.30	1,180.50	97.10
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,985.00</b>	<b>5,584.20</b>	<b>2,400.80</b>	<b>69.93</b>
210702	Дотоод албан томилолт	7,985.00	5,584.20	2,400.80	69.93
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,597.10</b>	<b>20,447.91</b>	<b>2,149.19</b>	<b>90.49</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,838.90	19,132.94	1,705.96	91.81
210803	Даатгалын үйлчилгээ	108.90	108.90	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149.30	149.30	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.00	100.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200.00	956.77	243.23	79.73

**Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

210807	Газрын төлбөр	200.00	0.00	200.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,026.30</b>	<b>26,805.12</b>	<b>5,221.19</b>	<b>83.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,700.00	19,085.42	3,614.59	84.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,326.30	7,719.70	1,606.60	82.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>82,517.10</b>	<b>80,765.46</b>	<b>1,751.64</b>	<b>97.88</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,517.10	80,765.46	1,751.64	97.88
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,500.00	3,500.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,123.80	52,900.40	223.40	99.58
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,893.30	24,365.06	1,528.24	94.10
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>409,779.60</b>	<b>265,513.26</b>	<b>144,266.35</b>	<b>64.79</b>
223001	Бусад хөрөнгө	409,779.60	265,513.26	144,266.35	64.79
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>140,000.00</b>	<b>70,000.00</b>	<b>70,000.00</b>	<b>50.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	140,000.00	70,000.00	70,000.00	50.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	185,706.85	-185,706.85	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	120,595.81	-120,595.81	0.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>54</b>	<b>54</b>	<b>54</b>	<b>100.00</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	2	100.00
610001	Төсвийн байгууллага	2	2	2	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	26	100.00
620001	Удирдах ажилтан	4	4	4	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	17	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	5	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	26	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10	10	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8	8	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	8	100.00

**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>7,569.79</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,569.79</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>7,569.79</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>7,569.79</b>
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,569.79</b>
<b>350014</b>	<b>Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө</b>	<b>7,254.79</b>
<b>350015</b>	<b>Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого</b>	<b>315.00</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,569.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,569.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,569.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,271.11</b>
<b>210104</b>	<b>Урамшуулал</b>	<b>1,271.11</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,298.68</b>
<b>210402</b>	<b>Тээвэр, шатахуун</b>	<b>2,148.68</b>
<b>210403</b>	<b>Шуудан, холбоо, интернэтийн төлбөр</b>	<b>150.00</b>

2105	Нормативт зардал	4,000.00
210502	Хоол, хүнс	4,000.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 42.0 сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Баянзүрх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 3.2 сая төгрөгийн зөрчил илэрч, холбогдох байгууллагад зөвлөмж өгсөн байна.

### 5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

ТТЗ-ийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Байгууллагын дотоод хяналтын талаар

##### 1.1 Аудитын илрүүлэлт:

Засаг даргын дэргэдэх дотоод хяналтын нэгж нь тайлант онд 6 ажил төлөвлөсөн боловч 2 ажилд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 36 дугаар зүйлийн 36.6-д “Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Дотоод аудит /аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах/ дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

#### 2. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

**2.1 Илрүүлэлт:** Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй 9 зээлдэгчийн нийт 18.0 сая төгрөгийн зээлийг барагдуулаагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2.1.“орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах

#### 3. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**3.1 Илрүүлэлт:** Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 3 нэр төрлийн нийт 14.0 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын аж ахуйн нэгжийн орлого 4.1 сая төгрөг,

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

дотоод бараа үйлчилгээний НӨАТ-н 5.9 сая төгрөгөөр нийт 10.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:** Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах

#### 4. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

**4.1 Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудсанд нийт 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4.1 хэсэгтэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд дараах зөрчил илэрсэн.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

**4.2 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлж ажиллах

#### 5. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

**5.1 Илрүүлэлт:** Баянзүрх сумын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хянаж үзэхэд нээлттэй болон харьцуулалтын аргаар төндөр зарлах боломжтой ижил төрлийн ажлуудыг жижиглэн, үнийн дүнг багасган шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 10 дугаар зүйлийн 10.3. Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

**5.2 Өгсөн зөвлөмж:** Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үнийн дүнг хуваахгүй нийт дүнгээр нь зохион байгуулах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн										

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын	Нийт зөрчил	Үүнээс

**Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянзүрх ТТЗ	4	42.0					4	42.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>42.0</b>					<b>4</b>	<b>42.0</b>				
<b>Харьяа байгууллагуудын зөрчил</b>												
Баянзүрх ЗДТГ	1	2.6					1	2.6				
Баянзүрх Соёлын төв	1	0.6					1	0.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3.2</b>					<b>2</b>	<b>3.2</b>				
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>45.2</b>					<b>6</b>	<b>45.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
Баянзүрх ТТЗ	1	-						1	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0.0</b>